

Д.Төмөртогоо: Ингэ бусад хүний хувьд мал. Миний хувьд бол ээж
Д.Пүрэвсүрэн

Энэ удаагийн “ҮШ-ийн хоймор”-тоо Олон улсын монгол судлалын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга, академич Д.Төмөртогоог урилаа.

Олон улсын монголч эрдэмтдийн XI их хурал ирэх наймдугаар сард болно

-Олон улсын монгол судлалын холбооны сонин сайхнаас яриагаа эхлэх үү?

-Олон улсын монгол судлалын холбоо байгуулагдаад 40 гаруй жил болсон, олон улсад монгол судлалыг дагнан явуулдаг байгууллага. Манай үндсэн чиглэл бол дэлхийн монголч эрдэмтдийн үйл ажиллагааг хооронд нь уялдуулах, монгол судлалын мэдээллээр хангах. Үүнээс хамгийн том ажил нь олон улсын монголч эрдэмтдийн их хурлуудыг тогтмол хуралдуулах, мөн “Монгол судлалын сэтгүүл” цувралыг түгээн тараахад чиглэдэг. Анхны хурал 1959 онд болсноос тооцох юм бол ирэх наймдугаар сард олон улсын монголч эрдэмтдийн XI хурал болох гэж байна. Санхүүжилт нэлээд оройтож шийдэгдсэн учраас бэлтгэл ажил орой эхэлсэн. Одоогоор гадаадын 200 гаруй эрдэмтэн оролцохоор саналаа ирүүлээд байгаа.

-Хэр хугацааны давталттай болдог хурал бэ?

-Таван жилд нэг удаа болдог юм. Нэг хуралд дунджаар 300 гаруй эрдэмтэн, дотоодын 100 орчим эрдэмтэн оролцож, 350-аад илтгэл хэлэлцдэг. Хуралд дунджаар дэлхийн 25-30 орны эрдэмтэд оролцдог, дэлхий дээрх, монгол судлалын олон улсын хэмжээн дэх хамгийн том хурал. Олон улсын эрдэмтэд хүсэн, хүлээж байдаг, тогтмолжсон хурал л даа.

-Таван жилд нэг удаа гэхээр ач холбогдлын хувьд нэлээд өндөр байх нь ээ?

-Олон орны монголч эрдэмтэд цуглаад, өөрсдийн бүтээл туурвилыг танилцуулах мөн өөрийн судалгааны чиглэлийн эрдэмтэдтэй уулзаж, ном бүтээлээ солилцох, биечлэн танилцах зэрэг боломжтой. Нөгөө талаар монгол орноо сурталчлах, гадаад бодлогын бас нэг том хэлбэр байгаа юм. Гиймээс бүр социализмын үеэс төр засгаас дэмжиж, энэ хурлыг санхүүжүүлж ирсэн. Энэ хурал Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор болдог.

-Сүүлд Ерөнхийлөгчийн санаачилгаар хаагдахад хүрээд байсан монгол судлалын төвүүдийг эргэн нээж, олон улсын монгол судлалыг өргөжүүлэхэд анхаарч эхэлсэн тухай мэдээлэл гарч байсан. Одоо бодит байдал ямар байна вэ?

-1990-ээд он гарснаас хойш Европ, Америкийн нэлээд олон төв хаагдаж, заримынх нь үйл ажиллагаа их хязгаарлагдмал болсон байсан. Засгийн газраас үүнд нэлээд анхаарч, монгол судлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг 2015 онд баталсан. Мөн 2013 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар Монгол судлалыг дэмжих санг байгуулсан. Одоо Монгол судлалын үндэсний зөвлөл гэж Ерөнхий сайдаар ахлуулсан бүтэц бий. Ингэж хууль эрх зүйн талаасаа нэлээд арга хэмжээ авч, олон улсын монгол судлалыг дэмжихэд тодорхой ажлууд хийсэн. Өнгөрсөн хоёр жилийн байдлаар Германы Боннын Их сургуульд хаагдсан байсан Монгол судлалын төвийг дахин байгуулж, тэнд ажиллаж байгаа багш нарын цалингийн тал хувийг манай талаас олгож байгаа. АНУ дахь Берклийн Их сургуулийн Монгол судлалын төвийг байгуулахад манайх зохих хэмжээний тусламж үзүүлж, өнгөрсөн жилээс үйл ажиллагаагаа явуулж байгаа. Үүнээс гадна Унгарын Будапештийн, Чехийн Прагийн, Польшийн Варшавын Их сургууль болон Австралийн Канберра хот дахь Үндэсний Их сургуулийн монгол судлалын төвүүдэд зохих хэмжээний санхүүгийн тусламж үзүүлсэн. Мөн Петербургийн Шинжлэх ухааны академийн дэргэдэх салбарт бас тусламж үзүүлсэн.

-Танаас ярилцлага авах гэж хоёр ч удаа уулзахад их л завгүй байх юм. Ер нь ажлын долоо хоног тань хэрхэн өнгөрдөг вэ?

-Хурал болох гээд ойрд бүр завгүй байна. Ер нь ч завтай байна гэж байхгүй. Өөрийн судалгааны ажилдаа гол цаг заваа зарцуулдаг. Энэ ажлын хувьд хурлын бус үед бол тийм их яаруу сандруу ажилгүй. Олон улсын монгол судлалын төвүүдээс мэдээлэл авах, авсан мэдээллээ боловсруулж, орчуулж дамжуулах ажлыг хийдэг.

-Судалгааны чиглэл тань юу билээ?

-Монгол хэлний түүхэн судлал. Үүн дотроо монгол хэлний үүсэл гарал, олон мянган жилийн турш хэрхэн өөрчлөгдөж ирснийг авианы, үгийн түвшинд судалдаг. Нөгөө чиглэл нь монгол хэлний эртний бичгийн дурсгалууд. 700-800 жилийн өмнөөс монгол бичгээр, уйгаржин монголоор, дөрвөлжин үсгээр, араб, хятад үсгээр үлдсэн эртний бичгийн дурсгал, түүний хэлний онцлогийг судлах нь миний гол ажил. Эртний бичгийн дурсгалуудын эмхэтгэл, уйгаржин монгол бичгийн дурсгал, дөрвөлжин, араб үсгийн дурсгалын гурван ном гаргасан. Одоо чадвал хятад үсгээр тэмдэглэсэн монгол хэлний бүх дурсгал болох толь бичгийг эмхэлж гаргахаар оролдож байгаа.

Монгол хэлний эртний бичгийн дурсгалууд. 700-800 жилийн өмнөөс монгол бичгээр, уйгаржин монголоор, дөрвөлжин үсгээр, араб, хятад үсгээр үлдсэн эртний бичгийн дурсгал, түүний хэлний онцлогийг судлах нь миний гол ажил.

-Та энэ чиглэлийн судалгаагаа хэдийнээс эхлэв?

-60-аад жил болсон байна. Бүр оюутан байхаасаа л монгол хэлний бичгийн дурсгал, хэлний түүхэн хувьсал, хөгжлийн асуудлыг сонирхож эхэлсэн. Түүнээс хойш тасралтгүй судалж байна. Энэ талаар 10 гаруй ном, 70-80-аад өгүүлэл бичсэн. Мөн тооны олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцож байсан.

-Монгол судлал руу цэвэр өөрийн сонирхлоор оров уу, таныг хөтөлсөн хүн бий юү?

-Мэдээж багшийн нөлөө байна л даа. Миний багш бол академич, Шадавын Лувсанвандан. Мөн миний хамгийн анхны эрдэм шинжилгээний өгүүллийг уншиж хэвлүүлэхийг зөвшөөрсөн хүн бол Б.Ринчин багш. Ер нь 1960-аад оны эхээр манай салбарт Б.Ринчин, Ц.Дамдинсүрэн, Ш.Лувсанвандан гэж гурван академич байсан. Залуу судлаачдын бичсэн өгүүллийг тэдний гарын үсэгтэйгээр л хэвлэдэг байсан. Тэр бол нэлээд сайн шалгуур. Нэг бичсэн өгүүллийг олон дахин буцаана, багш нарынхаа зөвлөснөөр дахин засаж үзүүлнэ. Хэдийгээр өөрсдөө их ажилтай ч залуу судлаачдынхаа ажлыг үздэг, зөвлөдөг үе байлаа.

-Та эрдмийн ажлаасаа хөндийрч байсан үе байсан уу?

-Байхгүй. Би гадаадад ажиллаж байхдаа ч судалгаагаа хийж л байсан. Гадаадад бол бэлэн номын сантай, цаг зав нь ч их болохоор судалгаа хийх боломж бүр ч илүү байдаг. Би ер нь судалгааны ажлаасаа хөндийрч байсан удаа байхгүй ээ.

-Тэгвэл таны судалгааны хамгийн оргил үе гэвэл?

-Хүний ажлын идэвхтэй үе бол харьцангуй залуу нас байдаг. Гэхдээ эрдэм шинжилгээний ажлын хувьд нас ахих тусам цуглуулсан мэдлэг, хуримтлуулсан туршлага, арга зүй улам нэмэгддэг учраас үр бүтээл нь ахимаг насанд илүү харагддаг гэж боддог. Миний багш Ш.Лувсанванданы хамгийн алдартай бүтээлүүд дандаа л 50 наснаас хойш гарсан байдаг. Одоо би жилд нэг ном хэвлүүлдэг. Гэхдээ нэг сэдэвт зохиол бичнэ гэдэг бол тийм амархан үйлдвэрлээд байдаг ажил биш л дээ. Олон жилийн турш зэрэг хийж байсан ажлуудын маань дуусах хугацаа л тэгж таарч байгаа болохоос биш нэг жилд бичдэг ном гэж байхгүй шүү дээ.

-Ер нь та мэргэжилдээ хэрхэн дурлаж байв?

-Академич, философич, гүн ухаанч Г.Лувсанцэрэн гэж миний багш, хожим миний найз болсон хүн 1959 онд Унгарын Будапештэд судалгааны ажлаар яваад эргэж ирэхдээ Берлинд хэвлүүлсэн Турфаны цуглуулга гэж XIII зууны уйгаржин монгол бичгийн дурсгалуудыг эхээр нь хэвлэсэн ном авчирсан. Тэр номыг анх харснаас хойш уншиж судлах сонирхол төрж, түүгээрээ дипломын ажил бичсэн. Турфаны бичээс бол 1312 онд

Бээжин хотод хэвлүүлсэн 12 хуудас тасархай цаас бөгөөд түүнийг Германы судалгааны ангийнхан олсон. Одоо Берлинд эх нь байдаг.

-Манай судлаачдын хувьд бичгийн дурсгалууд Монголд цөөн байдаг учраас судалгаа хийж суухаас гадна эрэл хайгуулд их цаг зав зардаг байх даа?

-Тэгэлгүй яахав. Монголд монгол хэлээр бичсэн бичгийн дурсгал олон боловч яг манай нутаг дэвсгэрт уламжилж үлдсэн зүйл бол маш ховор шүү дээ. Цөөн тооны хөшөөний бичээс байхаас биш XIII-XIV зууны бичгийн дурсгал үнэндээ Монголд байхгүй. Гадаадын номын сан, архиваас л олж авдаг. Дээхэн бол гадаадад гарсан номыг олж авахад их хэцүү байсан. Гаднын эрдэмтэдтэй танилцаж байж, ном солилцох л гол арга байсан. Улс орон бүрд танилтай, тэдэнтэйгээ ном солилцдог байлаа. Тэр үед хардлага сэрдлэг их байсан учраас шуудангаас ирсэн номыг задалж үздэг, шалгадаг байцаадаг байв. Хоёрдугаарт, би өөрөө гадагшаа явж ном цуглуулна. Ялангуяа хувилдаг машин бий болсноос хойш ховор, чухал номыг хувилж авах боломжтой болсон. Жишээ нь, би Японд байхдаа их хэмжээний судалгааны материалыг хэвлэж авсан маань одоо ч хэрэг болдог.

Монголд монгол хэлээр бичсэн бичгийн дурсгал олон боловч яг манай нутаг дэвсгэрт уламжилж үлдсэн зүйл бол маш ховор.

-Өдөрт ширээний ард хэдэн цаг сууж байна вэ?

-Наад зах нь 12:00 цаг л биз.

-Олон жилийн дадал, зуршил бүр амьдралын хэв маяг болчихдог байлгүй?

-Залуу байхад шөнийн 2-3 хүртэл суудаг, түүнийгээ цагаа зөв зарцуулж байна гэж боддог байлаа. Хожим харахад сайн зүйл биш байна лээ. Хүн унтах цагтаа унтаж, ажиллах цагтаа ажиллаж байх ёстой юм байна.

-Та багадаа ингэний сүүгээр угжуулж өссөн гэж нэг ярилцлагадаа хэлсэн байсан. Бага насны тань тухай яриагаар ярилцлагынхаа хоёр дахь хэсэгт орёё.

-Би хөдөөний хүүхдүүдийн л адил мал маллаж өссөн. Хөдөө өссөн хүн байгалийг таних, ан амьтныг хайрлах үзэл нь илүү байдаг юм болов уу. Ном зохиол уншихад ч гэсэн хөдөө өссөн хүний бичсэн зохиол, мэдрэмж илүү санагддаг. Миний өсөж төрсөн гэрт алгын чинээ, утаатай 2-3 судар л байсан. Би тэрийг мэдэхгүй юм чинь задалж үзээгүй. Гэвч номын мөр хөөсөөр өдийг хүрсэн. Гадаадад хүмүүстэй танилцаад “Би мал хариулж өссөн, малчны хүүхэд” гэхээр үнэмшдэггүй. Гаднынхан бол хэд хэдэн үе дамжсан сэхээтний удамтай, баялаг номын сантай орчинд хүмүүжсэн хүмүүсийг л тэр хэмжээнд хүрдэг гэж ойлгодог болохоор тэр.

-Та айлын хэд дэх хүүхэд вэ?

-Би хоёр дахь нь юм гэсэн. Гэхдээ миний дээр нэг ах байсан нь тогтоогүй учраас намайг өргүүлсэн юм билээ.

-Та төрөл садантайгаа холбоотой байдаг биз дээ?

-Ерөөсөө төрөл садан гэж байхгүй, мэдэхгүй. Ээжийн аавынх сумаас баруун тийш, манайх сумаас зүүн тийш. Миний багад машин гэж байсан биш. Зун нь морь, бусад үед тэмээ л голдуу унана. Хоёр өртөө газар гэдэг чинь 60 км. Би хонины бэлчээрээс холдож үзээгүй.

-Та сумдаа арван жилээ төгсөөд, хот руу орж ирсэн үү?

-Тэгэхэд сумд арван жил байгаагүй шүү дээ. Би Ханбогд сумдаа дөрвөн жилээ төгсөөд, дараа нь Цогтцэций сумд долоодугаар ангиа төгсөж, Өмнөговийн төвийн дунд сургуульд аравдугаар ангиа төгсөж байсан. 70 жилийн өмнө намайг сургуульд анх орж байсан үед амьдрал ахуй хэцүү байлаа. Дөнгөж дайн дууссаны дарааг хэлэх үү, үзэг цаас олодохгүй. Ноос, түүхий эд тушаасан бичгийн ар дээр тугалгаар бичнэ. Заримдаа хэвлэсэн номын мөрний завсраар бичнэ. Анхны дэвтэр бас хэцүү, ширүүн цаастай, хулс нь тээглээд харандааны үзүүр хугалчих гээд байдаг байж билээ. Анхны шинэ дэвтэр,

харандаа их содон үнэртэй. Ер нь ангид нэг л шинэ юм гарч ирвэл ангиараа үнэртэнэ. Багш бакал гуталтай ороод ирэхэд л гутлынх нь тос содон үнэртдэг байж билээ.

-Хэлний мэргэжилтэй болсон нь таны сонголт байв уу, хувь тохиол уу?

-Ном сонирхоно. Бас шүлэг бичих гэж оролдоно. Хааяа түүнийгээ аймгийн сонин дээр тавиад өгсөн мөнгөөр нь молоко аваад уучихна. Их сургуульд ороод, хөдөө сангийн аж ахуй дээр байж байтал нэг өглөө босоход цас орсон байна. Тэгээд “Анхны цас” гэдэг шүлэг бичих уралдаан зарладаг юм байна аа. Би оролцтол миний шүлэг хамгийн муу байж таарав. Тэгээд л больсон. Тэгж шүлгээр “явахгүйгээ” мэдсэн нь сайн болсон. (инээв) Манай ангид Жамбал гэж хүү байсан юм. Тэр бид хоёр нэг орой оюутны байранд шөнийн 2-3 цаг хүртэл ярьсан. Тэгэхэд “Чи ерөөсөө хэлний судлаач” бол гэж намайг сэнхэртэл хэлж байсан юм. Тэр шөнөө би унтаагүй, байгаа хэдэн номоо эргүүлээд үүр цайлгаж байсан. Хэлний хүн болоход ангийн минь найз л чиглүүлсэн юм шүү.

-Нутаг орон руугаа хэр явж байна вэ?

-Төрөл садан, ах дүү гэж байхгүй болохоор ховор доо. 1951 онд хамт төгссөн манай ангийнхнаас 7-8 хүн байдаг юм. Тэдэнтэйгээ хааяа очиж уулздаг юм. Сая чиний өмнөхөн сумын дарга орж ирээд, энэ зун сумдаа ирээрэй гэж урьсан. Очно доо.

-Та сумаасаа төрсөн ганц академич уу?

-Тийм. Өмнөговийос ганц байдаг юм.

-Та хэдэн настайдаа анх докторын цолоо хамгаалж байв?

-Их хожуу. Энэ их түүхтэй. Диссертацаа 20 хэдэн настайгаасаа л бичиж байсан юм. Гэхдээ тухайн үед будилаанд ороод, миний бичсэн ажил зөвшөөрөгдөхгүй, хойшилсоор байсан. Тэгээд 20 хэдэн насандаа диссертац бичээд 52-тойдоо хамгаалсан шүү дээ.

-Ямар будилаан юм бол?

-Японд байхдаа монгол англи япон толь хэвлүүлсэн юм. Тэр толийнхоо толгой үгийг үгийн үндэс язгуур эвдэхгүйгээр хийсэн юм. Гээх гээгдэх эгшгийг гээхгүйгээр хийтэл үсгийн дүрэм гуйвуулсан гэдэг асуудалд ороод л миний эрдмийн зэрэг хамгаалах, гадаад явах эрх зэрэг ажил 11 жил хойшилсон. Түүнийг би хэлмэгдсэн гэж үзэхгүй. Бас өөрийгөө буруутай ч гэж үздэггүй. Яахав цагийн уур амьсгал л тийм байсан юм чинь.

-Бас л олон жилийн шийтгэл байна шүү.

-Яг 11 жил болсон юм. Тэгж байтал 1989 онд сэтгүүлч Ц.Дашдондогийн бичсэн нэг өгүүлэл “Үнэн” сонинд гарсан. Тэр өгүүлэлд “Энэ хүний эрдмийн зэргийг нь хамгаалуулахгүй удаж байна” гэж бичсэн. Тэр үеийн “Үнэн” сонин их хүчтэй байсан шүү дээ. Өгүүлэл гарсны маргааш нь л Төв хорооноос дуудаад “Үүнээс хойш ийм асуудал гарахгүй, зэргээ хамгаалж болно” гэсэн. Тэгээд тэр намраа би Боннын Их сургуульд багшаар явчихсан юм. 1990 онд Монголын нууц товчооны 750 жилийг олон улс даяар тэмдэглэж, Монголд том хурал болсон. Тэгэхэд Монголд ирж, докторын зэргээ хамгаалсан.

-Та тэр цаг хугацаандаа харамсдаггүй юу?

-Үгүй. Судалгаагаа хийхийг маань хориглоогүй учраас би хийх ажлаа хийгээд л явж байсан. Намайг гадагшаа яваад ирэхэд миний шавь нар аль хэзээний эрдмийн зэрэг авчихсан байсан. Тэгэхэд би юм бодоо ч үгүй. 1990 онд дэд эрдэмтэн, 2-3 жилийн дараа доцент болоод, тэгээд профессор гээд богино хугацаанд цол хэргэмүүдийг авсан. Түүнийг би хөөцөлдөөгүй, миний хийж байсан ажлын үр дүн юм уу л гэж боддог.

-Номын хүмүүс голдуу дөлгөөн тайвуу харагддаг. Таны хувь чанар?

-Би өөрийгөө дөлгөөн хүн гэж хэлж чадахгүй. Яаруу сандруу л хүн. Гэхдээ бусдад төвөг чирэгдэл болоод байдаггүй. Цагт нэлээд баригддаг. Цагт нэлээд харамч учраас яардаг байх.

-Та нэг их яриа хүн биш байх аа?

-Гайгүй дээ. Нэг их чалчаад байхгүй ээ.

-Гэхдээ тийм хүмүүс нэг хэлэхдээ хошин өнгө аястай хэрнээ хоржоонтой үг хэлдэг.

-Надад тийм хошин зан байхгүй ээ. Би бол ярианы чадвар маш муу хүн шүү дээ. Багаасаа их бүрэг байсан, одоо ч хэвээрээ.

-Танай хүүхдүүдээс тантай адил хэлний мэргэжилтэй хүн бий юү?

-Байдаггүй ээ. Нас ахиад ирэхээр номын сандаа санаа зовох юм. Би хэл шинжлэлийн хувьд гайгүй номын сантай гэж боддог. Болдог бол эрдэмтдийн сайхан цуглуулгатай, чухал номуудыг авдаг, хадгалдаг газартай баймаар байна. Энэ асуудал их яригддаг юм. Манай том эрдэмтдийн номын ихэнх нь үрэгдсэн. Уг нь гадаадад тухайн хүний нэрийн тэнхимтэй, номыг нь бүгдийг бүртгэлжүүлсэн, хүмүүс ороод уншдаг байдаг. Манайд тийм юм алга.

-Нас ахих тусам бага насны дурсамжууд тодордог гэдэг. Таны мартагддаггүй дурсамж юу вэ?

-Надад мартагддаггүй зүйл бол тэмээ л байгаа юм даа. Багадаа өнчин өссөн болохоор ингэний сүүгээр боожсон хүн. Ингэ бусад хүний хувьд бол мал, миний хувьд ээж шүү дээ. Уян, зөөлөн сэтгэлтэй сайхан амьтан. Гадаадад байж байхад дэрэн дээр толгой тавихаар гудамжны чимээ, машин тэрэг, дуу хөгжим сонсогдох ч надад бол ботго уяан дээрээ буйлаад л, цаанаас нь ингэж гунганаад ирж байгаа нь бичлэгт бичсэн юм шиг тодорхой сонсогддог. Тэр бол сэтгэлд хоногшсоных л байдаг байх. Түүнээс биш би нутаг орноо, тэмээгээ санаад байгаа юм байхгүй л дээ.

-Хөдөө өссөнөөс гадна бараг хүнээс илүү малтайгаа ойр байсан болохоор тэгж хоногших нь аргагүй байх л даа?

-Тийм шүү. Би мал их эрхлүүлдэг хүүхэд байсан юм. Өнчин ишиг, хэнз хургатай хамт л нэг гэрт амьдарна шүү дээ. Тэгж өссөн мал хүнд амархан эрхэлдэг. Бүгд нэртэй устай, дуудахад бараг хүрээд ирдэг. Орой мал хотлохоор зэлэн дээр очиж, уяатай бүх ботгоо эрхлүүлнэ. Малчин байсан бол би одоогийнхоосоо амжилттай явах байсан байх. (Инээв)

-Тэмээ их эрх үү? Хангайд бол сарлаг их эрх байдаг юм.

-Их эрх. Том болсон хойноо ч эрхлээд л байна. Бүр ат болчхоод үүдээр толгойгоо оруулаад ирнэ. Юм гуйгаад уруул нь өмөлзөөд байдаг. Гэхдээ буцаж гарахдаа толгойгоо тонгойлгохоо мэдэхгүй гацчихна. Үхрийн занг би мэдэхгүй. Ойртохоос бараг айдаг. (инээв) Ер нь мал сайхан шүү. Манай бүх мал нэртэй устай, гэр бүлийн нэг гишүүн шиг байдаг байсан. 100 малтай ч шөл гаргая гээд хотонд орохоор тэрний минь тэр гээд муулах мал олддоггүй шиг.

-Багадаа та тэмээ л хариулж байв уу?

-Манайх тийм баян айл байгаагүй ээ. Тэмээ, зун унадаг цөөн адуу, нэлээд ямаатай байсан. Миний өргөж авсан ээж ямаанд их хайртай хүн байсан юм. Тэр үед улсаас малыг өсгөн нэмэгдүүлэх бодлого барьдаг, тэр хэмжээгээр ноос, ноолуур тушаах төлөвлөгөөтэй байсан. Жишээ нь, энэ жил 100 тоо толгой байсан бол дараа жил заавал 120 болгон өсгөх хуультай байсан юм. Гэвч хорогдсон малын ноос, ноолуурыг гүйцээж өгч чадахгүйгээс болж олон хүн орон шоронд явж байлаа. Тийм хүнд үе байсан юм.

-Багаасаа малтай ойр өсөх хүүхдийн хүмүүжилд их нөлөөлдөг санагддаг.

-Малыг хайрладаг хүн бол хүнийг хайрлаж л таарна шүү дээ. Мал хайрладаггүй, нохой хайрладаггүй, зоддог нүддэг бол хүнд ч бас тэгж л ханддаг байх. Мал хүнийг хүмүүжүүлэхгүй ч тэр орчин бол яах аргагүй учрах хайрлах сэтгэлийг бий болгодог.

-Тэгвэл та сайн малчин болох байжээ?

-Баатар болдоггүй юм гэхэд сумын сайн малчинтайгаа л байх байсан байлгүй. (инээв)

-Сүүлийн үед хэлний дархлаа муудлаа гэх мэтээр их ярьдаг болж. Та ямар бодолтой байдаг вэ?

-Аливаа зүйлийг байнга тордож байж авч явдаг. Хэл бас түүнтэй адил эмзэг. Хэл устлаа, гадаад үг их орж ирлээ гэж байна. Санаа тавих нь зөв хэрэг. Гэхдээ сөнөж байна гэж хэлж байгаатай би санал нийлэхгүй. Хэл бохирддог ч эргээд цэвэршиж байдаг зүйл. Их мөрний усанд бохир юм орж л байдаг. Урсгалаараа түүнийг цэвэрлэж л байдаг шүү дээ. Энгийн жишээ хэлэхэд, 50-60 жилийн өмнө ширээ гэж хэлдэг хүн байгаагүй. Стол гэдэг байсан. Больниц, сестра санитар, шиприц гээд бүгд орос байсан. Одоо түүнийг хэрэглэж байгаа нэг ч хүн байхгүй шүү дээ. Ингэж 50-60 жил монгол хэлэнд орос хэлний үгс идэвхтэй байсан мөртлөө одоо байхгүй болчихож байгаа шүү дээ. Ер нь хэлний хэдэн хувь гадаад үг байх вэ гэдэг хэмжээ байдаг л даа. Тэгэхээр гадаад хэлийг хэт үгүйсгэж болохгүй, монголоор хэлж болдог байхад чамирхаж гадаадаар ярьж бас болохгүй, олон улсын нэр томъёо болсон үгнээс зугтаад бүгдийг нь монголчилоо гэвэл бас өрөөсгөл болно. Ийм л тэнцвэрийн асуудал.

Олон мянган жил уламжилж ирсэн хэлийг хэдхэн жилийн дотор устгана гэж байхгүй л дээ. Тухайн хэлээр яриад хүнийг уурлуулж, инээлгэж, уйлуулж чадаж байвал тэр хэлэнд хүч байна гэсэн үг. Өнөөдөр манай монгол хэл хүнийг дээд зэргээр уурлуулж чадна. Инээлгэж чадна. Тэгэхээр манай хэлний чадал байна гэсэн үг. ЮНЕСКО-гоос бие даасан хэлний шинжийг тодорхойлсон байдаг. Түүнийг үзвэл монгол хэл тийм мөхлийн ирмэгт тулсан хэл биш ээ. Жишээ нь, байгалийн, техникийн гэх мэт шинжлэх ухааны нарийн зүйлсийг монгол хэлээр бичиж байна шүү дээ. Их дээд сургуулийн бүх сургалт монголоор явж байна. Эрдэм шинжилгээний сэтгүүлүүд бүгдээрээ монгол хэлээр гарч байна. Энэ бол хэлний дээд зэргийн хэрэглээ. Эрэмбэлэх юм бол шинжлэх ухааны хэл хамгийн дээд эрэмбэ шүү дээ. Үүнийг нэр томъёо, найруулгатай нь эх хэлээрээ гаргаж чадаж байгаа нь манай хэлний чадвар маш сайн байна гэсэн үг. Гэхдээ сайн гээд орхиж болохгүй, байнга хамгаалж хадгалах ёстой л доо.

ЮНЕСКО-гоос бие даасан хэлний шинжийг тодорхойлсон байдаг. Түүнийг үзвэл монгол хэл тийм мөхлийн ирмэгт тулсан хэл биш ээ.

-Хэлтэй холбоотой асуудлаар таны хамгийн эмзэглэж явдаг зүйл юу вэ?

-Мэдээж хэлээ цэврээр нь хадгална гэдэг хойш нь тавьж болохгүй зүйл. Миний хамгийн гол эмзэглэж явдаг зүйл бол залуучууд үгийн баялаг маш цөөтэй байна. Жишээ нь, намайг бага байхад “Хоньчин Найдан” зохиолыг багш уянгалуулаад уншихад ангиараа эхэр татаад уйлдаг байсан юм. Одоо залууст уншиж өгвөл ойлгодог хүн хэдэн хувь байх вэ. Ялангуяа хотод байгаа залуус. Дээр нь үгийн сан, үгийн уран дүрслэл, ялангуяа зүйр цэцэн үг бүр байхгүй болсон. Хуучны хүмүүс үгэн дотроо зүйр үг маш их хэрэглэдэг байсан. Хариулахдаа ч гэсэн нэг зүйр үг хэлээд л орхидог. Тэр нь оновчтой, гүнзгий утгатай байсан. Зүйр үг бол манай хэлний баялаг шүү дээ. Газрын баялгаар жиших юм бол алт нь. Өвөр Монголд бол зүйр цэцэн үг хэрэглэх нь манайхаас илүү. Хятад кино орчуулахад л монгол зүйр үг оруулаад шигтгээ хийчихсэн байгаа юм. Өвөр Монголын сургуулиудад зүйр цэцэн үг цээжлүүлдэг юм байна л даа. Гэхдээ хагасыг нь хэлээд хагасыг нь өөрсдөөр нь хэлүүлдэг юм байна. Жишээ нь, цувж явсан бараас ...гээд цааш нь юу гэдэг билээ.

-Цуглаж суусан шаазгай дээр.

-Тэгж хэлэх байтал “Цувж явсан бараас бөөн тоос манарна” гэсэн байгаа юм. (инээв) Шинэ үеийнхэн тийм л болчихоод байна. Дунд сургуулийн сургалтад хэлний зүй заагаад байх нь гол биш. Үгийн баялагтай болгохын тулд уламжлалт зүйр цэцэн үг, аман зохиол үлгэрийг сургалтад их нэвтрүүлэх хэрэгтэй гэж боддог. Тийм хичээлийг өмнө нь Үг бичгийн хичээл гэдэг байсан. Тэр хичээл хурдан ороосой гэж бид хүлээдэг байлаа. Сүүлдээ хэл ярианы хичээл ч билүү, нэр нь өөрчлөгдсөн байсан.

-Хөгжиж буй орнууд соёлын хатуу бодлого барьдаг. Тэгснээрээ тэднийг ардчилсан улс биш гэдэггүй, харин ч уламжлалт соёлоо авч үлддэг тухай та хэлсэн

байсан. Манай улсын хувьд уламжлалаа сэргээх, хадгалах гарцыг та юу гэж хардаг вэ?

-Одоо цагт монгол соёлын талаар ярих нь багадаагүй. Ярьж байгаагийнхаа хэмжээгээр төр засгаас тогтоол гарч л байна. Тэр нь ч бас багадаагүй. Түүнийг хэрэгжүүлнэ гэвэл бодитой арга хэмжээ авах хэрэгтэй. Даанч амьдрал дээр хэрэгжиж байгаа нь тун бага. Хэчнээн сайхан хууль эрх зүйн боломж байлаа ч гэсэн хэрэгжүүлэх механизм нь, хөрөнгө мөнгө нь байхгүй бол цаасан дээр л үлдэж байгаа юм. Зах зээлийн нийгэмтэй орнуудад төр заавал бүгдийг хариуцдаггүй. Бизнесийн хүмүүс ёс зүйн хувьд өөрийн үндэсний соёл, үнэт зүйлээ хөгжүүлэх, хайрлаж хамгаалахад оролцох, орлогын тодорхой хувийг нь зарцуулдаг жишиг их байдаг. Манайд бол бизнесийн ёс зүй гэхээр морь мал, бөх гээд их өөр зүйлд л зарцуулдаг байх юм. Тэгтэл насаараа юм хийсэн эрдэмтэн хүн амьдралаа дөнгөж залгуулах хэмжээнд байдаг. Оюуныг үнэлэх үнэлэмж гэдэг зүйл бол улс төрийн соёл, нийт хүний соёлын асуудал юм даа. Одоо бол тэр хэмжээнд хүрээгүй л байна.

-Энэ Засгийн газар шинжлэх ухааныг нэлээд үгүйсгэлээ. Энэ нь хөгжиж буй орнуудын хувьд төлөвших явцад гардаг л зүйл юм болов уу. Эсвэл манайх л ингэж эсрэгээрээ яваад байна уу?

-Гаднын орнууд ийм байсан эсэхийг мэдэхгүй юм. Орос, Хятадын жишээн дээр ярихад удирдагч нарынх нь хэлсэн бүх үгэнд шинжлэх ухаанд тулгуурласан гэж байдаг. Ялангуяа манай өмнөд хөршийнхөн шинжлэх ухаанд маш их ач холбогдол өгдөг. Харин манай Их хурал, Засгийн газраас гарч байгаа бичиг сачигт шинжлэх ухаанд тулгуурласан гэдэг үг тун ховор доо. Шинжлэх ухаан бол бүх салбарын хөгжлийн түлхүүр шүү дээ. Шинжлэх ухааны үр дүн хэтдээ гардаг ч хийсэн хөрөнгө оруулалтаа хэд нугалсан үр дүнтэй байдаг. Оюунд суурилсан эдийн засаг, инновац гэж сүүлийн үед их ярьж байна. Энэ бол зөв. Үүнийгээ хэрэгжүүлэхэд их зөв хандах ёстой. Жишээ нь тухайн яамны сайд хүн мэргэжлийнх байх ёстой. Одоо бол хэн хамаагүй хүн хүрч ирээд ямар ч яамны суудалд суучхаж байна шүү дээ. Ингэхээр тэр хүн салбарынхаа асуудлыг ойлгох болтлоо нэлээд удна. Ойлгоод байж байтал дараагийн сонгууль болдог. Дөрвөн жилийн сонгууль олон улсад хэрэгжиж байгаа засаглалын гол хэлбэр. Гэхдээ үүнийг шүүмжилсэн шүүмж их байдаг. Хэдэн жилийн өмнө АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Хэнри Киссенжерийн өгүүллийг уншиж байсан. Тэнд Хятадын эдийн засаг яагаад тогтвортой хөгжиж байна вэ. Бусад нь яагаад тиймгүй байна вэ? гэдэг талаар бичсэн байсан. Төр тогтвортой, бодлого нь тогтвортой байхад л улс орон хөгжинө. Манайд тийм зүйл л дутаад байгаа юм.

Эх сурвалж: <https://eagle.mn/r/12849>